

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
1	Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	-	Шалгалт хийсэн объектын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 50%	-Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5*5.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолыг үндэслэн "Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай" тушаалын төслий боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/15 дугаар тушаалыг	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>батлуулсан. -Тушаал болон Салбарын хяналт, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг яамны албан ёсны вэб сайтын ил тод хэсэгт байршуулсан. /https://www.meds.gov.mn/post/152456 / -Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу Шинжлэх ухааны академийн Физик технологийн хүрээлэнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж ажилласан.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
2	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100% Зөрчил арилгуулалтын хувь - 90%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 60%	-Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах зорилгоор ажлын хэсгийн хамт Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль, Олон улсын эдийн засаг бизнесийн их сургууль, ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Орхон дээд сургууль, Хангай дээд сургууль, Санхүү бизнесийн дээд сургууль, Мон Алтиус дээд сургууль, Оточ манрамба дээд сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Налайх дахь МГТИС, Отгонтэнгэр их сургууль, Их Засаг Олон улсын их	3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сургууль, Рояль их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, ОУ-ын Улаанбаатарын их сургууль, Этүгэн их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Эрдмийн их сургууль, Аварга дээд сургууль, Технологийн дээд сургууль, Хөдөлмөр нийгмийн харилцааны дээд сургууль, Шинэ Монгол дээд сургууль зэрэг нэр бүхий 35 сургуульд хяналт шалгалт хийж ажилласан. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

1.2. Шинжлэх ухааны чиглэлээр хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх хяналт тавих

3	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь	-	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 30%	-Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5*3.1 дэх хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний хүрээнд ХААИС-ийн харьяа Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийг боловсруулж, батлуулсан. /Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03-00/14 дугаар бүхий/ -Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 тушаалаар байгуулсан дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
---	---	---	---	---	--	------------------	---

					<p>үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа 3, 4, 5 дугаар сард үргэлжлэн хийгдсэн тул тус шалгалтыг 08 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр хойшлуулсан. Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
4	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулахад оролцох	Зохион байгуулсан аяны тоо Хамрагдсан байгууллага, хүний тоо Үр дүн	Аян зохион байгуулсан аймаг - 0	Аян зохион байгуулсан аймаг - 1	<p>Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг 2024 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдөр Төв, 04 дүгээр сарын 09-11-ний өдөр Хэнтий, 05 дугаар сарын 02-05-ны өдөр Булган, 05 дугаар сарын 09-10-ны өдөр Сэлэнгэ аймагт тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд Шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлого төлөвлөлт, шийдвэрийг танилцуулах зорилго бүхий эрдэм шинжилгээний хурал, шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээний үзэсгэлэн, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөгөөт болон захиалгат сургалт, төр-хувийн хэвшил-эрдэмтдийн хамтын ажилагааны санамж бичиг зурах арга хэмжээ, мөн шинэ мэдлэг, ноу-хау-г бий болгох гарааны бизнесүүдийн сургалт, “Эрдэм Хакатон” уралдаант тэмцээн зэргийг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнд төр, хувийн</p>	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	<p>Өөрийн үнэлгээ: 60%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ: 70%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%</p>

					хэвшлийн эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн нийт 17 байгууллагын 40 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, үзэсгэлэн гаргасан байна. Нэг аймагт дунджаар 250 гаруй төр, хувийн хэвшлийн байгууллага, судалгааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл аяны арга хэмжээнд оролцсон дүн мэдээ байна. Энэхүү арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажилд оролцсон. Хавсралт: 1 файл		
5	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргах	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ Зөрчил арилгуулалтын хувь	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ -0 Зөрчил арилгуулалтын хувь-60%	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ -1 Зөрчил арилгуулалтын хувь-60%	ШУА-ийн физик, технологийн хүрээлэнд хэрэгжиж буй суурь судалгаа, гадаадтай хамтарсан, үндсэн чиглэлийн хүрээнд хийгдэж буй төслүүдийн хэрэгжилтийн явцад шинжилгээ хийж ажиллалаа. 2024 оны байдлаар тус хүрээлэнд суурь судалгааны төсөл 3, Гадаадтай хамтарсан 2, Судалгааны үндсэн чиглэлийн хүрээнд санхүүжилтээр 4 чиглэлийн төсөл хэрэгжиж байна. Тус хүрээлэн нь АНУ, Герман улстай хамтран хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа ба энэ хүрээнд нүүрсээр дулааны асуудлаа шийдвэрлэдэг байсан 3 цэцэрлэгийг дулааны хураагуураар дулааны асуудлаа зохицуулах боломжтой болгосон байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хүрээлэнгийн гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн, илгээсэн Эрдэм шинжилгээний	4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					өгүүлэл, ишлэлийг хувилж үзэхэд дундаж нь 88 хувьтай байна. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргах ажил үргэлжилж байна. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	---	--	--

1.3. Зөрчлийн хэрэг бүртгэлтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах

6	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах	Зөрчлийн тоо Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь	Зөрчлийн тоо - 130 Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь - 89,8%	Зөрчлийн тоо - Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь - 80%	1.Нийслэлийн боловсролын газар, аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын эрх бүхий албан тушаалтнуудаас улирал тутамд илрүүлсэн зөрчил, түүнд авсан арга хэмжээний судалгааг авч, нэгтгэх ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яам-2, Нийслэлийн боловсролын газар-53, Завхан аймаг-3, Сэлэнгэ аймаг-2, нийт 60 зөрчлийг прокурорын байгууллагад бүртгүүлэн, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Эдгээрийн торгууль шийтгэврийн барагдуулалт 100 хувь. 2.УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам", Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан УЕП, НПГ-аас ирүүлсэн мэдээллийг салбарын нийт	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	---	---	---	---	---	---

					<p>улсын байцаагчдад цахим групп болон албан тоотой хүргүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Энэ хүрээнд аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, улсын /ахлах/ байцаагч нарт “Аргачлал журмын хэрэгжилт хангуулах тухай” 13/1523 дугаартай албан тоотыг боловсруулж хүргүүлсэн. 3.Баян-Өлгий аймгийн улсын байцаагч Болатад Зөрчлийн хэргийн бүрдүүлбэр, Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагч Ө.Хишигдолгорт улсын байцаагчийн эрх хүсэхэд бүрдүүлэх материалын бүрдлүүд, зөрчлийн хэрэг үүсгэх, прокурорын байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлын талаар мэдээлэл өгч, арга зүйгээр ханган ажилласан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
7	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-5 Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь-100	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь-80%	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны хэмжээнд: -Улсын ахлах байцаагч Д.Өнөржаргал Салбарын хяналтын газрын даргын баталсан 03-00/16 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцдаа гадаадын хөрөнгө оруулалттай "Найтын Австрали-Монгол" ЕБС нь боловсролын стандарт /Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS6782:2019/, сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн, улсын комисс хүлээж аваагүй байгууламжид үйл ажиллагаа явуулсан зөрчил илрүүлснийг зөрчлийн талаарх</p>	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	<p>Өөрийн үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал:</p>

				<p>гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэлд бүртгэн, мэдээллийг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлж ажилласан. - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн удирдлага болон зарим багш хууль бус төлбөр хураамж авсан гэх гомдлыг Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргасан үндэслэлээр "Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэл"-д бүртгэв. Уг мэдээллийг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн. -БШУЯ-ны ЦЦАБХГ-ын цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч Н.Од-Эрдэнэ Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан 03-01/11 дугаартай удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх явцдаа "Чайна энерги инженеринг групп анхуй электрик повер констракшн хоёрдугаар инженеринг" ХХК нь цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахад тавих шаардлагыг зөрчиж, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан зөрчлийг илрүүлснийг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэлд бүртгэн, хуулийн хугацаанд Нийслэлийн</p>		100%
--	--	--	--	--	--	------

					<p>прокурорын газарт хүргүүлсэн. Салбарын хэмжээнд: -НБГ, аймгуудын БШУГ-ын эрх бүхий албан тушаалтнууд 58 зөрчлийг прокурорын байгууллагад бүртгүүлсэн.</p> <p>Хавсралт: 3 файл</p>		
8	Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны хэрэглээнд хяналт тавих	Шийтгэлийн хуудасны тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалт-70%	Шийтгэлийн хуудасны тоо-Тухай бүр /58/ Торгууль шийтгэврийн барагдуулалт-80%	Шийтгэлийн хуудасны тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалт-70%	<p>-Тайлант хугацаанд Салбарын хяналтын газар, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Нийслэлийн боловсролын газрын улсын /ахлах/ байцаагчдад Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах шийтгэлийн хуудас буюу маягт 2-оос 5 ширхэг, Шийтгэлээс чөлөөлөх хуудас буюу маягт 5-аас 37 нийт 42 шийтгэлийн хуудсыг шаардах хуудсаар олгож, бүртгэлжүүлсэн. -Эрх бүхий албан тушаалтнуудаас шийтгэлийн хуудсаар нийт 7.2 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан ба торгууль шийтгэврийн барагдуулалт 100 хувь байна.</p> <p>Хавсралт: 2 файл</p>	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	<p>Өөрийн үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%</p>
9	Эрх бүхий албан тушаалтны судалгааг өөрчлөлт гарсан даруйд шинэчлэн прокурорын байгууллагад хүргүүлэх	Хүргүүлсэн судалгааны тоо	Судалгааны тоо-4	Судалгааны тоо-Тухай бүр	<p>-Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн Эрх бүхий албан тушаалтны талаарх нэмэлт мэдээлэл авах тухай Ц-1/260 албан тоотын дагуу Боловсрол, шинжлэх ухааны яамны Салбарын хяналтын газар, Цөмийн болон цацрагийн хяналтын газрын эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг шинэчлэн гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.</p>	1-р сар, 3-р сар, 9-р сар, 12-р сар	<p>Өөрийн үнэлгээ: 100%</p> <p>Нэгжийн даргын үнэлгээ: 95%</p> <p>Нэгжийн даргын</p>

					Хавсралт: 3 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-21	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-Тухай бүр	-УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам"-ыг баталсан, Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг 05 сарын 01-ээс хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан УЕП, НПГ-аас ирүүлсэн мэдээллийг салбарын нийт улсын байцаагчдад цахим групп болон албан тоотоор хүргүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. -Аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, улсын /ахлах/ байцаагч нарт "Аргачлал журмын хэрэгжилт хангуулах тухай" 13/1523 дугаартай албан тоотыг боловсруулж хүргүүлсэн. -Салбарын улсын ерөнхий байцаагчийн 13/1523 дугаартай албан бичгийн хүрээнд аймгуудын БШУГ-ын дарга, улсын /ахлах/ байцаагчдаас ирүүлсэн төлөвлөгөөг нэгтгэн, санал боловсруулсан. -Говь-Алтай аймгийн БШУГ-ын улсын байцаагч	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>Ц.Түмэнжаргалд "Цэцэрлэгийн багш хүүхэд зодсон" асуудлын тухайд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тухайн гомдлыг аймгийн Цагдаагийн байгууллагад шилжүүлүүлсэн. - Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн албан тоотын дагуу 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Удирдлагын манлайллыг дээшлүүлж, хууль хэрэглээг сайжруулах нь" сэдэвт хамтарсан зөвлөгөөний тухай мэдээллийг холбогдох албан хаагчдад хүргэж, оролцоог хангуулах ажлыг зохион байгуулсан. -Баян-Өлгий, Завхан, Төв аймгийн улсын /ахлах/ байцаагчдад зөрчлийн хэрэг бүртгэл, торгох шийтгэл, эрх зүйн хэлбэрүүдийг зохистой ашиглах талаар зөвлөгөө өгч ажилласан. - Нийслэлийн боловсролын газар, аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын улсын /ахлах/ байцаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 3 файл</p>		
--	--	--	--	--	---	--	--

3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

1 1	Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах ажлыг хариуцан зохион	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо - 14 Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ -	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ -	-Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн Сүхбаатар, Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалыг хашиж байсан Л.Байгалмаа, А.Болормаа болон Төв аймгийн БШУГ-ын улсын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн
--------	---	--	---	--	---	--	--

байгуулж, үнэмлэх, тэмдгийн хэрэглээнд хяналт тавих		100%	100%	байцаагчаар ажиллаж байсан Р.Солонго, СХГ-ын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан М.Нямсүрэн нарын 4 ЭБАТ-ны улсын /ахлах/ байцаагчийн эрхийг цуцлах тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. -Баянхонгор аймгийн БШУГ-ын мэргэжилтэн М.Мөнхбат, Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагч Ө.Хишигдолгор нарын 2 ЭБАТ-д улсын байцаагчийн эрх олгох тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. -Улсын байцаагчийн 03-16-00/035 дугаар бүхий үнэмлэх, тэмдгийг үрэгдүүлсэн тул "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ын 5.1, 5.2-т заасны дагуу уг үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцох тухай тушаалын төслийг боловсруулж батлуулсан. -Хас тамга үйлдвэрт захиалга өгч, 03-16-00/073 дугаар бүхий тэмдгийг гаргуулан авах ажлыг зохион байгуулсан. -Засгийн газрын 2023 оны 6 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ын 3.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/581 дүгээр тушаалыг үндэслэн улсын байцаагчийн 03-16-00/035 дугаартай үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцсон болохыг "Өглөөний сонин" сонины 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн №053 /4066/ дугаарт хэвлэн нийтлүүлсэн. -Боловсрол, шинжлэх	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	------	------	---	--	---

					<p>ухааны сайдын тушаалаар улсын байцаагчийн эрх олгосон Баянхонгор, Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагч М.Мөнхбат, Ө.Хишигдолгор нарт олгох үнэмлэхийг загварын дагуу хэвлүүлж, албажуулан бүртгэл хөтлөн олгосон. -Салбарын хяналтын газрын Эрх бүхий албан тушаалтнуудын тамга тэмдгийн дардсын судалгааг 2 удаа авсан. - Нийслэлийн боловсролын газрын эрх бүхий албан тушаалтнуудын тамга тэмдгийн дардсын судалгааг журамд заасны дагуу мөн 2 удаа авсан.</p> <p>Хавсралт: 8 файл</p>		
1 2	Улсын байцаагчийн үйлдсэн хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгож, хяналт тавих	Олгосон хэвлэмэл хуудасны тоо Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - 192 Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - 55	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - Тухай бүр Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - Тухай бүр	Тайлант хугацаанд буюу 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар улсын ахлах байцаагчдад - Хяналт шалгалтын удирдамжийн хэвлэмэл хуудас 30, -Хяналт шалгалтын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас 188, -Улсын ахлах байцаагчийн албан шаардлагын хэвлэмэл хуудас 53, -Хяналт шалгалтын танилцуулгын хэвлэмэл хуудас 4, -Улсын ахлах байцаагчийн акт 2, -Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийн хэвлэмэл хуудас 2, - Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн хэвлэмэл хуудас 10, нийт 289 хэвлэмэл хуудсыг бүртгэлд аван олгосон байна. Мөн тайлант хугацаанд -Хяналт шалгалтын удирдамж 24, -Албан шаардлага 20, -Зөвлөмж 1, нийт 45 хяналт	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шалгалтын баримт бичгийг хянаж, нэгдсэн дугаар олгон бүртгэлжүүлсэн. Хавсралт: 2 файл		
1 3	Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь	100%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - 100 Гүйцэтгэлийн хувь - 100%	-Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт ажиллаж байна. Тус ажлын хэсгийн 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон. -Хуваарийн дагуу "Нийгмийн баталгаа" багийн гишүүд ажлын төлөвлөгөө, зураглалыг гарган 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тус ажлын хэсгийн нийт бүрэлдэхүүнд танилцуулсан. - Салбарын хяналтын газрын даргын чиглүүлсэн гурван удаагийн Сайдын шуурхай хурлаас өгсөн 32 үүрэг даалгаврын нэгтгэлийг гаргаж, биелэлтийг системд бүрэн оруулсан эсэхийг нягталж, тулгалт хийн холбогдох газруудаар биелэлтийг системд оруулуулсан. -Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчдын хууль хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд хоёр байгууллагатай гэрээ байгуулах, хөтөлбөр боловсруулах, тушаалын төсөл боловсруулж батлуулах зэрэг ажлыг гүйцэтгэж байна. -Нийслэлийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавих хэлтсийн дарга Б.Соёлсайхан, хяналтын прокурор Г.Сундуй нартай хийсэн 2 удаагийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>уулзалт, ярилцлагад оролцсон. - Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 тушаалаар байгуулсан дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн 3 удаагийн нэгдсэн хурал, 3 удаагийн санал солилцох уулзалтад оролцсон. -Салбарын хяналтын газраас зохион байгуулсан бодлогын газруудад 2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг танилцуулах, харилцан мэдээлэл, санал солилцох уулзалт, арга хэмжээнд оролцсон. -Нэгжийн даргаас үүрэг болгосны дагуу Салбарын хяналтын газрын хурлын тэмдэглэлийг хөтлөн, албажуулах ажлыг тухай бүр гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд 4 удаагийн хурлын тэмдэглэлийг хөтөлсөн. - Салбарын хяналтын газар, Нийслэлийн боловсролын газар, аймгуудын БШУГ-ын улсын байцаагчдаас шаардлагатай техник, хэрэгслийн судалгааг авч, нэгж хооронд санал солилцох хуудсаар СХОГ-т хүргүүлсэн.</p> <p>Хавсралт: 6 файл</p>		
1 4	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Боловсруулж батлуулсан төлөвлөгөөний тоо	Боловсруулж батлуулсан төлөвлөгөөний тоо-1	Боловсруулж батлуулсан төлөвлөгөөний тоо-1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ:

							100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 5	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг шийдвэрлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн зохих заавар, журмыг мөрдөх	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо Шийдвэрлэлтийн хувь	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо -29 Шийдвэрлэлтийн хувь-100	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо - Тухай бүр Шийдвэрлэлтийн хувь-100	-Тайлант хугацаанд 6 албан бичиг, 2 хүсэлт /цаасаар-1, цахимаар 1/ хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. -Тайлант хугацаанд 8 тушаалын төсөл боловсруулж, батлуулсан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
1 6	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль түүнд	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.						Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 7	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Тайлангийн тоо	Тайлангийн тоо -2	Тайлангийн тоо-1	-Сарын ажлын тайланг тогтмол тайлагнасан. -Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр тайлагнасан.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталсан дүрэм журмыг уншиж судлах	Шинээр болон шинэчлэн баталсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	Хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.	Хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.	-Бие даан Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэхээр уншиж, судалж байна. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагаас зохион байгуулсан Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох тестийн шалгалтыг өгсөн. -Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажил эхэлж байгаатай холбогдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Боловсролын багц хуулиудыг уншиж судалсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх зорилгоор танхимын болон цахим сургалтад хамрагдах	Яам болон холбогдох бусад газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	Танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна.	Хамрагдсан тоо- Тухай бүр	-Удирдлагын академиас зохион байгуулсан "Манлайлал: Бусдад нөлөөлөх нь" сэдэвт лекцэд хамрагдан, "Смарт Дийл" компанийн үүсгэн байгуулагч Д.Болорын тавьсан илтгэлийг сонсон "Манлайлал яагаад чухал сэдэв болов, Зорилго үнэт зүйл гэж юу вэ, Даяаршил 3.0, Алсын хараа-Эрхэм зорилго, үнэт зүйл, Бусдад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					<p>ээрэгээр нөлөөлөх аргууд” зэрэг агуулгын хүрээнд шинэ мэдлэг, мэдээлэл авсан. -Байгууллагын ээлжит “Мэдээллийн цаг” арга хэмжээнд хамрагдан Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Анарагийн “Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент” сэдэвт лекцийг сонсон, сорилд хамрагдсан. -Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга” сэдвээр мэдээлэл авсан. -Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (шилэн хяналт) ашиглалтад орж байгаатай холбогдуулан тус порталын ашиглалт, хэрэглээний талаарх цахим сургалтад хамрагдсан. -Удирдлагын академи буюу Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Төрийн чадамжийг бүрдүүлэх нь цахим, танхим хосолсон 24 цагийн хичээлийг судлан, шалгалт өгч 2024-02-07-ны өдөр №24/0210 дугаартай сертификатыг гардан авсан.</p> <p>Хавсралт: 5 файл</p>		
3	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц	Төрийн албаны сургуулийн Ахлах	-	Төрийн албаны сургуулийн ахлах	Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн	2-р сар, 3-р сар, 4-р сар,	Өөрийн

	сургалтад хамрагдах	түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна.		түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байна.	мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан суралцаж байна. Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
4	А3 сертификат авах	Онлайнаар сургалтад хамрагдаж А3 сертификат авах	-	А3 сертификат авсан байна.	Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдан, шалгалт өгсөн.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 80%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг /...../

Огноо: